Мэдвэл зохих зүйлс	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын аж ахуй, санхүү-эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг, харъяалах салбар, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон төрийн дээд байгууллага, засаг захиргааны тогтоол шийдвэрүүд. • Салбарын техник, эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөв. • Байгууллагын бүтцийн нэгжүүдийн онцлог. • Байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага-менежментийн аргачлалууд. • Байгууллагын үйлдвэрлэл-аж ахуй болон санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг боловсруулах, зөвшилцөж батлуулах журам. • Аж ахуйн болон санхүүгийн гэрээ байгуулах, түүнийг гүйцэтгэх журам. • Салбарын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын шинжлэх ухаан техникийн ололт амжилт, тэргүүн туршлага. • Байгууллагын санхүү, эдийн засгийн менежмент. • Аж ахуй болон хөдөлмөрийн зохион байгуулалт. • Хөдөлмөрийн, татварын, байгаль орчны болон бусад хууль тогтоомжууд • Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам. • Хөдөлмөрийн болон хамтын гэрээ, хэлэлцээр боловсруулах, хөдөлмөр-нийгмийн хамгааллын харилцааны зохицуулалт
IV. Харилцах субъект /ажлын уялдаа холбоо/	

а. Байгууллагын дотоод харилцаа			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
“Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” -ийн хэмжээнд	Нийт ажиллагсад	Үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, шалгах, холбогдох ажлын шугамаар	Өдөр бүр
ТӨҮГ-ын хэлтэс, албад	ТӨҮГ-ын Захирал, газар, хэлтэс, албадын дарга, мэргэжилтнүүд	Үүрэг даалгавар авах, тайлагнах, холбогдох ажлын шугамаар	Цаг тухайд нь
б. Гаднын байгууллагуудтай харилцах			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
- Төр, захиргааны байгууллагууд - иргэн, хуулийн этгээд	Холбогдох албан тушаалтан	Холбогдох ажлын шугамаар	Тухайн цаг үед нь
V. Ажлын байранд тавигдах шаардлага			
Боловсрол (боловсролын зэрэг)	• Дээд, бакалавр түүнээс дээш		
Мэргэжил	• Уул уурхайн инженер эсвэл менежмент		
Мэргэшлийн бэлтгэл	•		
Ажлын туршлага	• удирдах албан тушаалд 2-с доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	• хамт олныг удирдан зохион байгуулах, • асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх,		
Тусгай шаардлага	• авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, • байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах		
VI. Ажлын байрны хангамж, эд хөрөнгө, нөөц хэрэгсэл			
Цалин	• хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал		
Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц хэрэгсэл	• албан өрөө, тавилга, эд хөрөнгө, компьютер, холбогдох техник хэрэгсэл		
VII. Ажлын байрны онцлог			
<ul style="list-style-type: none"> • Хөдөө орон нутагт ажиллах, • Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллана. 			
VIII. Ажил үүргийн хүрээнд эдлэх эрх			
<ul style="list-style-type: none"> • Төрийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, иргэдтэй харилцах харилцаанд Үйлдвэрийн газрын удирдлагаас өгсөн эрх хэмжээний хүрээнд МДУМССАЖТөвийн ашиг сонирхлыг төлөөлөх. • Монгол Улсын хууль, бусад эрх зүйн актууд болон Үйлдвэрийн газрын дүрэм, холбогдох журмуудаар тодорхойлсон шаардлагын дагуу зөвхөн Үйлдвэрийн газрын Захирлын зөвшөөрлөөр бэлэн мөнгө болон байгууллагын эд хөрөнгийг захиран зарцуулах. • Үйлдвэрийн газраас батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажилд авсан ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах. • Дараахь шийдвэрийг гаргах: <ul style="list-style-type: none"> - аж ахуйн ба хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн ажиллагсад, мөн байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан гэм буруутай этгээдэд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн болон сахилгын хариуцлага хүлээлгэх. - Үйлдвэрийн газарт үйлчилж буй холбогдох дүрэм журмын дагуу шилдэг тэргүүний ажилтнуудад материаллаг ба материаллаг бус урамшуулал олгох. • Шүүх, арбитрайн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд МДУМССАЖТөвийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, төлөөлөх ажлыг зохион байгуулах, холбогдох ажилтанд итгэмжлэл олгох 			

IX. Ажлын үр дүнгээр хүлээх хариуцлага

- МДУМССАЖТөвийн үйл ажиллагааны үр дүн хангалтгүй бол,
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу болон энэхүү ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгээгүй буюу хангалтгүй гүйцэтгэсэн бол,
- Өөрийн ажил үүргийг гүйцэтгэх явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд заасан зөрчил гаргасан бол,
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн заалтын хүрээнд материаллаг хохирол учруулсан бол,
- Холбогдох хууль тогтоомж, Үйлдвэрийн газрын дүрэм, журам болон бусад хууль эрх зүйн актуудад тогтоосноос илүү өөрийн эрх мэдлийг хэтрүүлж гаргасан шийдвэрийнхээ үр дагаварт,
- Хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн сахилга бат, Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн бол тус тус хариуцлага хүлээнэ.
- Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын
Захирал

Д.ТОГТОХСҮРЭН

2025 оны 03 сарын 26-ны өдөр

**“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН
ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

I. Ерөнхий мэдээлэл	
Байгууллагын нэр	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
Нэгжийн нэр	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар
Ажлын байрны нэр	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга
Албан тушаалын ангилал	Албан хаагч
Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын захирал
Ажлын байранд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс, Техник, хяналтын хэлтэс
Орлон ажиллах албан тушаал	Тогтоосон дүрэм журмын дагуу томилогдсон ажилтан
Ажлын цаг	Үйлдвэрийн газрын тогтоосон цагийн дагуу
Ажлын байрны нөхцөл	Хэвийн
II. Ажлын байрны зорилго	
<ul style="list-style-type: none"> Төрийн өмчит үйлдвэрийн газрын хэмжээнд дотоод хяналт, эрсдэл, техник хяналт, мониторингийн хамааралтай бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих гүйцэтгэлийг хангах 	
III. Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
Ажлын байрны үндсэн үүрэг	<ul style="list-style-type: none"> Жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж үйлдвэрийн газрын Захирлаар батлуулан, уг төлөвлөгөөний дагуу ажлын удирдамж гаргаж үйлдвэрийн газрын бүтцийн нэгж, харьяа үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд холбогдох хэлтэс, албад, мэргэжилтнүүдтэй хамтран хагас жил тутамд төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаарх зөвлөмж, буруутай этгээдэд холбогдох журмын дагуу арга хэмжээ авах саналын хамт тусган байгууллагын удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулан ажиллах. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, удирдлагыг мэдээллээр хангах; Байгууллагын захиргаа болон харьяа үйлдвэрүүдийн хэмжээнд дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтнуудын эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна мөн уул уурхайн үйлдвэрлэлийн үе шат бүрт бие болж байгаа бүтээгдэхүүний чанарыг хянах үйл ажиллагааг зохион байгуулах.
а. Үндсэн үүргийн хүрээнд ажлын байранд хийгдэх ажлууд	<ul style="list-style-type: none"> Хяналт шалгалтын үйл ажиллагаан дахь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг хангаж ажиллах; Үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоог сайжруулах талаар судалж, удирдлагад санал дүгнэлтийг танилцуулах; Хяналтын тогтолцоо, хяналтын үндсэн зарчмуудад тулгуурлан үр дүнтэй хяналтын системийг бүрдүүлж ажиллах, чиглэл өгөх;

- Үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт болон үр өгөөжийг судалж санал, дүгнэлтийг удирдлагад танилцуулах,
- “Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ыг боловсруулан мөрдүүлэх;
- Хяналт шалгалтын үйл ажиллагаан дахь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг хангах нөхцлийг бүрдүүлэх;
- дотоод хяналтын тогтолцоо, арга зүйг боловсронгуй болгох, дотоод хяналтын үндсэн зарчмуудад тулгуурлан үр дүнтэй хяналтын системийг бүрдүүлэх;
- жил бүр дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, удирдлагаар батлуулан мөрдөх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах;
- хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлэх;
- хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай бол зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар үйлдвэрийн газрын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- дотоод хяналтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;
- Үйлдвэрийн газрын зорилтот түвшин, эдийн засгийн төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах;
- Үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаарх санал зөвлөмж гарган удирдлагад танилцуулах;
- Үйлдвэрийн газрын хөрөнгө, өр төлбөр, зээл тусламж, орлого, зарлага, татвар хураамж, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл зарцуулалт, үр дүнд хяналт шалгалт хийх;
- Нэгдсэн менежментийн тогтолцоонд тулгуурлан Үйлдвэрийн газрын чанар, стандартын шаардлагад нийцсэн түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг хангах, хяналт тавих, холбогдох тайлан тооцоог гаргах, Үйлдвэрийн газрын бизнес-төлөвлөгөөнд тусгагдсан үзүүлэлтүүдийг хангаж ажиллах,
- Техник хяналтын хэлтсийн журамд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг хангаж ажиллах,
- Ээлж тус бүрт хийж гүйцэтгэсэн ажил, гарсан зөрчил, дутагдлыг бүртгэж, мэдээллээр удирдлагыг хангах,
- Үйлдвэрлэлийн үйл явц, үйлдвэрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, сахилга бат, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, албан тушаалтанд хариуцлага тооцуулах, байгаль орчин,

	<p>хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг сахиулах зорилгоор санал, зөвлөмжийг Үйлдвэрийн газрын захиралд бичгээр гарган, холбогдох шийдвэр гаргуулан ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> • Бичиг баримтын төсөл боловсруулахдаа зөв бичиг, найруулга зүйн дүрмийн болон архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартын шаардлагыг чанд баримтлан ажиллана. • Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
<p>б. Бусад ажил үүрэг</p>	<ul style="list-style-type: none"> • ISO стандартын нэгдсэн удирдлагын тогтолцооны болон бусад ISO стандартуудын хүрээнд батлагдсан журмуудад заасан энэхүү албан тушаалд хамааралтай ажил үүргийг цаг тухайд нь биелүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, • хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөж, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байхад анхаарах, • өөрт нь хамаарах чиг үүргийн хэрэгжилтэд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдлагад танилцуулах, • тодорхойлсон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ болон шаардлагатай нөөцийг төлөвлөх, танилцуулах, • эрсдэлийг удирдах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, холбогдох хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, • хэрэгжилтийг эрсдэлийн удирдлагын чиг үүрэг хариуцсан нэгж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, • эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явцад учирсан, эсхүл учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн эрсдэлийг мэдээллийн санд бүртгэж, шууд удирдлага болон эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжид мэдэгдэх, эрсдэлийн түвшнээс хамаарч холбогдох арга хэмжээг авах саналаа эрх бүхий этгээдэд гаргах, • удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг цаг тухайд нь тогтмол чанартай гүйцэтгэнэ.
<p>Мэдвэл зохих зүйлс</p>	<p>-Хөдөлмөрийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, - Үйлдвэрийн газрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажиллагсдын ёс зүйн дүрэм, албан хэрэг хөтлөлтийн болон архивын ажлын заавар, журам, стандарт, бусад холбогдох дүрэм, журам, зааварчилгаа, -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулаас хамгаалах дүрэм, журам, -Үйлдвэрийн газрын болон харьяа салбар үйлдвэрүүдийн зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл; -Үйлдвэрийн газрын хяналтын тогтолцоо; -Хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм журам, заавар арга зүй; -Салбарын хөгжлийн хэтийн төлөв, -Үйлдвэрийн газрын болон харьяа салбар үйлдвэрүүдийн зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл хэмжээ; -Үйлдвэрийн газрын хэтийн хөгжлийн бодлого чиглэл, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл, зорилтот түвшин;</p>

	-Үйлдвэрийн газрын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа; -Үйлдвэрийн газрын дотоод хяналтын тогтолцоо; -Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм журам, заавар арга зүй; •		
IV. Харилцах субъект /ажлын уялдаа холбоо/			
а. Байгууллагын дотоод харилцаа			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
Хэлтэс, албад	Захирал, газар, хэлтэс, албаны дарга нар	Үүрэг даалгавар авах, тайлагнах, чиглэл өгөх	Өдөр бүр
Үйлдвэрийн хэмжээнд	Нийт ажиллагсад	Холбогдох ажлын шугамаар	Цаг тухайд нь
б. Гадны байгууллагуудтай харилцах			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
- Төр, захиргааны байгууллагууд - иргэн, хуулийн этгээд	Холбогдох албан тушаалтан	Холбогдох ажлын шугамаар	Тухайн цаг үед нь
V. Ажлын байранд тавигдах шаардлага			
Боловсрол (боловсролын зэрэг)	<ul style="list-style-type: none"> • дээд, бакалавр, түүнээс дээш зэрэгтэй 		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> • эдийн засаг, эрх зүйч эсвэл бизнес болон төрийн захиргааны удирдлага 		
Мэргэшлийн бэлтгэл	<ul style="list-style-type: none"> • төрийн захиргааны чиглэлээр мэргэшсэн байх. 		
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> • удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх. 		
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • дүн шинжилгээ хийх; • үндэслэлтэй санал боловсруулах; • асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх; • багаар ажиллах; • тайлан мэдээ боловсруулах, тайлагнах. 		
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> • авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; • байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах. 		
VI. Ажлын байрны хангамж, эд хөрөнгө, нөөц хэрэгсэл			
Цалин	<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал 		
Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • албан өрөө, тавилга, эд хөрөнгө, компьютер, холбогдох техник хэрэгсэл 		
VII. Ажлын байрны онцлог			
<ul style="list-style-type: none"> • Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллана. 			
VIII. Ажил үүргийн хүрээнд эдлэх эрх			
<ul style="list-style-type: none"> • Өөрийн үйл ажиллагаатай холбоотой Үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэрийн төсөлтэй танилцах; • Энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар удирдлагад санал тавих; • Өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцад илрүүлсэн Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбогдолтой алдаа дутагдлыг шууд удирдлагад мэдээлэх, арилгах санал оруулах; 			

- Ажил үүргийн дагуу өөрийн эрх, үүргийг гүйцэтгэхдээ Үйлдвэрийн газрын удирдлагаас тусламж хүсэх;
- Хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгах, хамтран ажиллах талаар санал боловсруулах.

IX. Ажлын үр дүнгээр хүлээх хариуцлага

- Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг биелүүлээгүй эсвэл зохих есоор биелүүлээгүй бол,
- Өөрийн ажил үүргийг гүйцэтгэх явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд заасан зөрчил гаргасан бол,
- Үйлдвэрийн газарт эд материалын хохирол учруулсан бол учирсан хохирлын хэмжээгээр Монгол Улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн болон иргэний хууль тогтоомжийн хүрээнд,
- Хөдөлмөрийн сахилга бат, Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн бол,
- "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын удирдлагын түвшинд гаргасан шийдвэр, үүрэг даалгаврыг холбогдох дүрэм, журмын дагуу бүрэн гүйцэд, чадварлаг гүйцэтгэх, түүнчлэн албан бус зорилгоор мэдээллийг ашигласан,
- Үйлдвэрийн газрын нууц задруулсан бол,
- Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:

"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын

Захирал



Д.ТОГТОХСҮРЭН

20...26 оны ...01 сарын ...06-ны өдөр

“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. Ерөнхий мэдээлэл	
Байгууллагын нэр	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
Нэгжийн нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс
Ажлын байрны нэр	Хэлтсийн дарга
Ангилал	Албан хаагч
Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга
Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтсийн мэргэжилтнүүд, харьяа үйлдвэрийн дотоод хяналтын ажилтнууд
Орлон ажиллах албан тушаал	Тогтоосон дүрэм, журмын дагуу томилогдсон ажилтан орлон ажил үүргийг гүйцэтгэнэ. Тэрхүү ажилтан нь холбогдох эрхийг эдэлж, түүнд хавсаргасан ажил үүргийн чанар, гүйцэтгэлд хариуцлага хүлээнэ.
Ажлын цаг	Үйлдвэрийн газрын тогтоосон цагийн дагуу
Ажлын байрны нөхцөл	Хэвийн
II. Ажлын байрны зорилго	
<ul style="list-style-type: none"> Жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж үйлдвэрийн газрын Захирлаар батлуулан, уг төлөвлөгөөний дагуу ажлын удирдамж гаргаж үйлдвэрийн газрын бүтцийн нэгж, харьяа үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд холбогдох хэлтэс, албад, мэргэжилтнүүдтэй хамтран хагас жил тутамд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаарх зөвлөмж, буруутай этгээдэд холбогдох журмын дагуу арга хэмжээ авах саналын хамт тусган байгууллагын удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулан ажиллах. 	
III. Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
Ажлын байрны үндсэн үүрэг	<ul style="list-style-type: none"> “Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ыг боловсруулан мөрдүүлэх; Үйлдвэрийн газрын бусад бүтцийн нэгж, ажилтан, харьяа үйлдвэрийн удирдлага, нэгжтэй хэлтсийн уялдаа холбоог ханган, үйл ажиллагааг зохион байгуулах; хэлтсийн ажилтнуудыг чадваржуулах сургалтыг зохион байгуулах, удирдлагаар хангах, ажил үүргийн биелэлтэд хяналт тавих, ёс зүйн дүрмийг мөрдүүлэх; хяналт шалгалтын үйл ажиллагаан дахь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг хангах нөхцлийг бүрдүүлэх; дотоод хяналтын тогтолцоо, арга зүйг боловсронгуй болгох, дотоод хяналтын үндсэн зарчмуудад тулгуурлан үр дүнтэй хяналтын системийг бүрдүүлэх; жил бүр дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, удирдлагаар батлуулан мөрдөх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх; хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлэх;

	<ul style="list-style-type: none"> • хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай бол зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар үйлдвэрийн газрын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх; • дотоод хяналтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах; • хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, удирдлагад тайлагнах; • Үйлдвэрийн газрын зорилтот түвшин, эдийн засгийн төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах; • Үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаарх санал зөвлөмж гарган удирдлагад танилцуулах; • Үйлдвэрийн газрын хөрөнгө, өр төлбөр, зээл тусламж, орлого, зарлага, татвар хураамж, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл зарцуулалт, үр дүнд хяналт шалгалт хийх; • Харьяа үйлдвэрүүдийн дотоод хяналтын нэгж /ажилтан/-ийн үйл ажиллагааг шалгах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэлийг шалган цаашид сайжруулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.
<p>а. Үндсэн үүргийн хүрээнд ажлын байранд хийгдэх ажлууд</p>	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн газрын болон нэгж хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тайланд судалгаа дүгнэлт хийх; • Үйлдвэрийн газрын ажиллагсдын цалин урамшууллын систем, нийгмийн халамж, тусламжийн хүртээмж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих; • эрх бүхий байгууллагаас хийж буй хяналт шалгалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, шалгалтын дүнгээр өгсөн холбогдох зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийг үйлдвэрийн газрын бусад хэлтэс, нэгж, албан тушаалтнаар хангуулж ажиллах; • түүхий эд, бараа материал, бэлэн бүтээгдэхүүний бүртгэл, хөдөлгөөн, чанар, бүрэн бүтэн байдалд хяналт тавих; • өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалтын байдалд хяналт тавих; • санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон НББОУС, НБББББичгийн мөрдөлтөд дотоод хяналт тавих; • Үйлдвэрийн газрын өр төлбөр, авлага барагдуулалтын байдалд хяналт шалгалт хийх; • санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, шалгалт хийлгэх, тэдний өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах. • Үйлдвэрийн газрын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд бүхий л чиглэлээр хяналт тавих. • Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан холбогдох мэдээллийг хариуцсан ажилтнууд хуулийн цаг хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа эсэхийг хянана.

	<ul style="list-style-type: none"> • Бичиг баримтын төсөл боловсруулахдаа зөв бичиг, найруулга зүйн дүрмийн болон архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартын шаардлагыг чанд баримтлан ажиллана. • Архивын ажлын заавар, журамд заасны дагуу баримт бичигт техник боловсруулалт хийж хадгаламжийн нэгж бүрдүүлэн, цаг хугацаанд нь архивт шилжүүлнэ. • Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
<p>б. Бусад ажил үүрэг</p>	<ul style="list-style-type: none"> • ISO стандартын нэгдсэн удирдлагын тогтолцооны болон бусад ISO стандартуудын хүрээнд батлагдсан журмуудад заасан энэхүү албан тушаалд хамааралтай ажил үүргийг цаг тухайд нь биелүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, • хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөж, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байхад анхаарах, • өөрт нь хамаарах чиг үүргийн хэрэгжилтэд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, • тодорхойлсон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ болон шаардлагатай нөөцийг төлөвлөх, • эрсдэлийг удирдах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, холбогдох хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, • хэрэгжилтийг эрсдэлийн удирдлагын чиг үүрэг хариуцсан нэгж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, • эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явцад учирсан, эсхүл учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн эрсдэлийг мэдээллийн санд бүртгэж, шууд удирдлага болон эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжид мэдэгдэх, эрсдэлийн түвшнээс хамаарч холбогдох арга хэмжээг авах саналаа эрх бүхий этгээдэд гаргах, • удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг цаг тухайд нь тогтмол чанартай гүйцэтгэнэ.
<p>Мэдвэл зохих зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, худалдан авалтыг зохион байгуулах тухай Сангийн яамны журамууд болон бусад холбогдох хууль тогтоомж, • Үйлдвэрийн газрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажиллагсдын ёс зүйн дүрэм, албан хэрэг хөтлөлтийн болон архивын ажлын заавар, журам, стандарт, бусад холбогдох журам, зааварчилгаа, • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулаас хамгаалах дүрэм, журам, • Үйлдвэрийн газрын болон харьяа салбар үйлдвэрүүдийн зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл хэмжээ; • Үйлдвэрийн газрын хэтийн хөгжлийн бодлого чиглэл, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл, зорилтот түвшин; • Үйлдвэрийн газрын өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа; • Үйлдвэрийн газрын дотоод хяналтын тогтолцоо; • Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм журам, заавар арга зүй;

	<ul style="list-style-type: none"> Дотоод хяналт шалгалтын чиглэлээр дотоодын болон гадаад улсын туршлага. 		
IV. Харилцах субъект, объект /ажлын уялдаа холбоо/			
а. Байгууллагын дотоод харилцаа			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
Бүх хэлтэс, албад	Захирал, газар, хэлтэс, албаны дарга нар, мэргэжилтнүүд	Үүрэг даалгавар авах, өгөх, тайлагнах, биелэлтийг шалгах	Өдөр бүр
Үйлдвэрийн газрын хэмжээнд	Нийт ажиллагсад	Холбогдох ажлын шугамаар	Тухайн цаг үед нь
б. Гаднын байгууллагуудтай харилцах			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
- Төр, захиргааны байгууллагууд, - хуулийн этгээд	Холбогдох албан тушаалтан	Холбогдох ажлын шугамаар	Тухайн цаг үед нь
V. Ажлын байранд тавигдах шаардлага			
Боловсрол /боловсролын зэрэг/	<ul style="list-style-type: none"> Дээд, бакалавр түүнээс дээш 		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> Хууль эрх зүй, санхүү, менежмент 		
Мэргэшлийн бэлтгэл	<ul style="list-style-type: none"> 		
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> санхүүгийн чиглэлээр 5-аас доошгүй жил, уул уурхайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх 		
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, тайлан мэдээ боловсруулах, бэлтгэх. 		
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> худалдан авах ажиллагааны хүчин төгөлдөр АЗ сертификаттай байх авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах. 		
VI. Ажлын байрны хангамж, эд хөрөнгө, нөөц хэрэгсэл			
Цалин	<ul style="list-style-type: none"> хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал 		
Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> албан өрөө, тавилга, эд хөрөнгө, холбогдох техник хэрэгсэл 		
VII. Ажлын байрны онцлог			
<ul style="list-style-type: none"> Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллана. 			
VIII. Ажил үүргийн хүрээнд эдлэх эрх			
<ul style="list-style-type: none"> Өөрийн үйл ажиллагаатай холбоотой Үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэрийн төсөлтэй танилцах; Энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар удирдлагад санал тавих; Өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцад илрүүлсэн Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбогдолтой алдаа дутагдлыг өөрийн шууд удирдлагад мэдээлэх, арилгах санал оруулах; Өөрөө болон шууд удирдлагын өгсөн үүрэг даалгаврын дагуу харьяа үйлдвэрүүдийн удирдлага болон мэргэжилтнүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулах, тэднээс шаардлагатай мэдээ мэдээлэл лавлах, авах; 			

- Ажил үүргийн дагуу өөрийн эрх, үүргийг гүйцэтгэхдээ Үйлдвэрийн газрын удирдлагаас тусламж хүсэх;
- Хяналт шалгалт явуулахдаа үйлдвэрийн газрын хэлтэс, нэгжийн болон харьяа үйлдвэрийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, баримт, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгах, танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;
- Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар компанийн удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулах;

IX. Ажлын үр дүнгээр хүлээх хариуцлага

- Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг биелүүлээгүй эсвэл зохих есоор биелүүлээгүй бол,
- Өөрийн ажил үүргийг гүйцэтгэх явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд заасан зөрчил гаргасан бол,
- Үйлдвэрийн газарт эд материалын хохирол учруулсан бол учирсан хохирлын хэмжээгээр Монгол Улсад мөрдөгдөж буй Хөдөлмөрийн болон Иргэний хууль тогтоомжийн хүрээнд,
- Хөдөлмөрийн сахилга бат, Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн бол,
- Боловсруулсан баримт бичгийн утга агуулгад алдаа гаргасан, түүний улмаас байгууллагад хохирол учруулсан бол,
- Үйлдвэрийн газрын нууц задруулсан бол.
- Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮТ-ын
Захирал


..... Д. ТОГТОХСҮРЭН

ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС
ТӨҮТ
20...26 оны 01 сарын 09 -ны өдөр
9025031012 н. 2550466

“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. Ерөнхий мэдээлэл	
Байгууллагын нэр	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
Нэгжийн нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс
Ажлын байрны нэр	Ахлах мэргэжилтэн
Албан тушаалын ангилал	Албан хаагч
Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтсийн дарга
Ажлын байранд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр	
Орлон ажиллах албан тушаал	Тогтоосон дүрэм, журмын дагуу томилогдсон ажилтан орлон ажил үүргийг гүйцэтгэнэ. Тэрхүү ажилтан нь холбогдох эрхийг эдэлж, түүнд хавсаргасан ажил үүргийн чанар, гүйцэтгэлд хариуцлага хүлээнэ.
Ажлын цаг	Үйлдвэрийн газрын тогтоосон цагийн дагуу
Ажлын байрны нөхцөл	Хэвийн
II. Ажлын байрны зорилго	
<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд “Дотоод хяналт шалгалт, аудитыг зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх 	
III. Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
Ажлын байрны үндсэн үүрэг	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, төрийн эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, хувийн ашиг сонирхлын зөрчил, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, түүнд заасан Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, салбар үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт хийх, дүгнэлт зөвлөмж өгөх, хяналт тавьж ажиллах.
а. Үндсэн үүргийн хүрээнд ажлын байранд хийгдэх ажлууд	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд “Дотоод хяналт, шалгалт аудитыг зохион байгуулах журам”-ын чиг үүргийг хэрэгжүүлэх, мөрдүүлэх)-ын хүрээнд: <ol style="list-style-type: none"> 1.1. Жил бүрийн эхэнд өөрийн гүйцэтгэх хяналт шалгалтын ажлын чиглэлийг тусган, саналаа хэлтсийн даргад гарган өгч дотоод хяналт шалгалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулан батлуулах; 1.2. Хяналт шалгалтын чиглэлээр тушаал шийдвэр төлөвлөн, хэлтсийн даргаар болон холбогдох албан тушаалтнуудаар хянуулан, батлуулах; 1.3. Хяналт шалгалтын ажлын хэсгийн болон өөрийн хийж гүйцэтгэх шалгалтын удирдамж, ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах; 1.4. Батлагдсан “Дотоод хяналт шалгалтын ажлын нэгдсэн төлөвлөгөө” болон хяналт шалгалтын ажлын удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх, зохион байгуулах;

	<p>1.5. Хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтлан ажиллах;</p> <p>1.6. Хяналт шалгалт явуулахдаа үйлдвэрийн газрын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, баримт, судалгаа авах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;</p> <p>1.7. Гүйцэтгэсэн болон зохион байгуулсан хяналт шалгалтын ажлын үр дүнгээр ажлын хэсгийн гишүүдээс тайлан, дүгнэлтийг гаргуулан авч нэгтгэх ажлыг зохион байгуулах, нэгдсэн тайланг боловсруулж холбогдох ажлын хэсгийн дарга болон хэлтсийн даргад танилцуулж, үр дүнг тайлагнах;</p> <p>1.8. Хяналт шалгалтын ажлын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгөх, шаардлагатай бол зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар хэлтсийн дарга болон үйлдвэрийн газрын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>1.9. Хяналт шалгалтын ажлын тайлан, үр дүнгээр үйлдвэрийн нэгж, газрын харъяа үйлдвэр, холбогдох албан тушаалтнуудад өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнд хүрсэн эсэхэд хяналт тавьж ажиллах;</p> <p>1.10. Үйлдвэрийн газрын харъяа үйлдвэрүүдийн дотоод хяналт шалгалт, харуул хамгаалалтын үйл ажиллагаа хариуцсан нэгж, ажилтны ажил үүрэгт нь хяналт тавьж ажиллах, сар бүрийн ажлын тайланг гаргуулан авах, тэдгээрийн гаргасан ажлын үзүүлэлт, алдаа дутагдал, сахилгын зөрчилд хариуцлага тооцуулах саналаа хэлтсийн даргад гаргаж шийдвэрлүүлэх;</p> <p>1.11. Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг танилцуулах;</p> <p>1.12. Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол холбогдох албан тушаалтан болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж, түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авахуулах.</p> <p>2. (Үйлдвэрийн газрын үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, стандарт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх)-ын хүрээнд:</p> <p>2.1. Харьяа үйлдвэрүүдийн олборлож байгаа төмрийн хүдэр, жоншны хүдэр, алтны тоо хэмжээг үйлдвэрлэлийн төлөвлөгөө, дүн мэдээнд тулгуурлан тулган шалгах, хүдрийн агуулга, чанар, стандартын байдалд хагас жил тутамд хяналт шалгалт хийх;</p> <p>2.2. Харьяа үйлдвэрүүдэд гадны байгууллагаас худалдан авч буй түүхий эд, жоншны хүдрийн агуулга, тоо хэмжээг гэрээний дүнтэй харьцуулан хагас жил тутамд шалгаж, гүйцэтгэлийг танилцуулах;</p> <p>2.3. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бэлэн бүтээгдэхүүн /төмрийн баяжмал, жоншны баяжмал,</p>
--	--

	<p>алт/-ий тоо хэмжээ, агуулга, чанар стандартад хагас жил тутамд хяналт шалгалт хийх;</p> <p>2.4. Харьяа үйлдвэрүүдээс гадны байгууллага, айл өрх, хувь хүнд аж ахуйн гэрээгээр үзүүлж буй ажил үйлчилгээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийх;</p> <p>2.5. Үйлдвэрийн газрын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх;</p> <p>2.6. Бараа, сэлбэг, материалын хадгалалт, хамгаалалт, чанар, ашиглалтын байдал, бараа материалын агуулах, тэсрэх материалын агуулах, нефть бүтээгдэхүүний агуулахын эмх цэгц, харуул хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх;</p> <p>2.7. Бараа материал, шатахуун, шатах тослох материал, тэсрэх материалын захиалга, хөдөлгөөн, үлдэгдэл, хэмжилт, тооллогын дүнд хяналт шалгалт хийж, үр дүнг танилцуулах;</p> <p>3. (Үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, үйл явц, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх)-ын хүрээнд:</p> <p>3.1. Үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн яамнаас баталсан худалдан авах ажиллагаатай холбогдолтой дүрэм, журам хэрэгжиж буй эсэхэд дотоодын хяналтыг гүйцэтгэх;</p> <p>3.2. Үйлдвэрийн удирдлагын зөвшөөрөл, шийдвэрээр харьяа үйлдвэрүүдийн сэлбэг, бараа материалын жилийн захиалга, байгууллагын Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөвт өртгийн тооцоолол, худалдан авах журмын сонголтод хяналт, дүн шинжилгээ хийх;</p> <p>3.3. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хараат бус, шударга байдал, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;</p> <p>3.4. Цахим худалдан авалт, худалдан авах ажиллагааны бүртгэл, мэдээллийн нээлттэй, ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>3.5. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд улирал тутамд хяналт шинжилгээ хийж, хэлтсийн дарга болон удирдлагад танилцуулах;</p> <p>3.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавын дагуу техник, тоног төхөөрөмж, сэлбэг, бараа материалын техникийн тодорхойлолт, ажил үйлчилгээний ажлын даалгаврын боловсруулалтыг хянан шалгах;</p> <p>3.7. Эрх бүхий байгууллагаас болон бусад аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс худалдан авах ажиллагаатай холбоотой ирсэн шаардлага, санал гомдлыг судлан дүгнэлт гаргаж удирдлагад танилцуулах, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах;</p> <p>3.8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний явц, биелэлтэд хяналт тавих;</p> <p>3.9. Худалдан авах ажиллааны дагуу гэрээгээр нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмж, сэлбэг, бараа материалын тоо хэмжээ, чанар, ашиглалтын байдалд хагас жил тутамд хяналт шалгалт хийх;</p>
--	--

	<p>3.10. Жил бүрийн эцэст худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн судалгаа гарган, Үйлдвэрийн газрын удирдлага болон холбогдох албан тушаалтанд саналаа гаргах;</p> <p>3.11. Жилийн эцэст худалдан авах ажиллагааны тайланд хяналт хийж, холбогдох саналаа хэлтсийн даргад танилцуулах;</p> <p>3.12. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны худалдан авалт, борлуулалт хариуцсан нэгжийн болон ажилтнуудын хагас, бүтэн жилийн ажлын тайланг гаргуулан, ажлын гүйцэтгэл, ачаалал, ур чадварт нь хяналт шинжилгээ хийх.</p> <p>4. (Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, мэргэжил мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх)-ын хүрээнд:</p> <p>4.1. Үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм болон бусад эрх зүйн актуудыг чанд мөрдөн ажиллах;</p> <p>4.2. Энэхүү ажлын байрны тодорхойлолтод болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан бусад эрх, үүргийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах;</p> <p>4.3. Авлигын эсрэг хуулийн хүрээнд гүйцэтгэж буй ажил үүрэгтээ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг холбогдох журмын дагуу гаргах;</p> <p>4.4. Ажлын байранд хариуцсан эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, албаны мэдээллийг ашиглахгүй байх;</p> <p>4.5. Үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэр, өгсөн итгэмжлэлийн үндсэн дээр өөрийнхөө ажил үүргийн чиглэлийн дагуу төрийн болон бусад хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагаанд байгууллагыг төлөөлж оролцох;</p> <p>4.6. Үйлдвэрийн газрын удирдлагын зөвшөөрлөөр өөрийн мэргэжил, мэдлэг, ажлын ур чадвараа дээшлүүлэх зорилгоор мэргэшүүлэх, давтан сургалт болон хурал, семинарт оролцох, үр дүнг тайлагнах;</p> <p>4.7. Байгууллага, хамт олны хүрээнд зохион байгуулж буй нийгмийн хариуцлагын, олон нийтийн, сайн дурын үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцох.</p> <p>5. Бичиг баримтын төсөл боловсруулахдаа зөв бичиг, найруулга зүйн дүрмийн болон архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартын шаардлагыг чанд баримтлан ажиллана,</p> <p>6. Архивын ажлын заавар, журамд заасны дагуу баримт бичигт техник боловсруулалт хийж хадгаламжийн нэгж бүрдүүлэн, цаг хугацаанд нь архивт шилжүүлнэ.</p>
<p>б. Бусад ажил үүрэг</p>	<ul style="list-style-type: none"> • ISO стандартын нэгдсэн удирдлагын тогтолцооны болон бусад ISO стандартуудын хүрээнд батлагдсан журмуудад заасан энэхүү албан тушаалд хамааралтай ажил үүргийг цаг тухайд нь биелүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, • хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөж, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байхад анхаарах,

	<ul style="list-style-type: none"> • өөрт нь хамаарах чиг үүргийн хэрэгжилтэд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, нэгжийн удирдлагад танилцуулах • тодорхойлсон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ болон шаардлагатай нөөцийг төлөвлөх, танилцуулах, • эрсдэлийг удирдах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, холбогдох хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, • хэрэгжилтийг эрсдэлийн удирдлагын чиг үүрэг хариуцсан нэгж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, • эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явцад учирсан, эсхүл учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн эрсдэлийг мэдээллийн санд бүртгэж, шууд удирдлага болон эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжид мэдэгдэх, эрсдэлийн түвшнээс хамаарч холбогдох арга хэмжээг авах саналаа эрх бүхий этгээдэд гаргах, • удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг цаг тухайд нь тогтмол чанартай гүйцэтгэнэ. 		
Мэдвэл зохих зүйлс	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, худалдан авалтыг зохион байгуулах тухай Сангийн яамны журамууд болон бусад холбогдох хууль эрх зүйн баримт, • Үйлдвэрийн газрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам; ажиллагсдын ёс зүйн дүрэм; албан хэрэг хөтлөлтийн болон архивын ажлын заавар, журам, стандарт; бусад холбогдох журам, зааварчилгаа, • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулаас хамгаалах дүрэм, журам, • Хууль, эрх зүйн мэдлэгтэй байх; • Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам • Үйлдвэрийн газрын үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, стандарт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал • Үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл • Үйлдвэрийн газрын дотоод хяналтын тогтолцоо • Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм журам, заавар арга зүй; • Дотоод хяналт шалгалтын чиглэлээр дотоодын болон гадны орнуудын туршлага. 		
IV. Харилцах субъект /ажлын уялдаа холбоо/			
а. Байгууллагын дотоод харилцаа			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давтамж</i>
Бүх хэлтэс, албад	Захирал, газар, хэлтэс, албаны дарга нар, мэргэжилтнүүд	Үүрэг даалгавар авах, тайлагнах, холбогдох ажлын шугамаар	Өдөр бүр
Үйлдвэрийн газрын хэмжээнд	Нийт ажиллагсад	Холбогдох ажлын шугамаар	Цаг тухайд нь

б. Гаднын байгууллагуудтай харилцах			
<i>Нэгж</i>	<i>Албан тушаал</i>	<i>Харилцах асуудал</i>	<i>Харилцах давамж</i>
- Төр, захиргааны байгууллагууд, - хуулийн этгээд	Холбогдох албан тушаалтан	Холбогдох ажлын шугамаар	Тухайн цаг үед нь
V. Ажлын байранд тавигдах шаардлага			
Боловсрол (боловсролын зэрэг)	<ul style="list-style-type: none"> • Дээд, бакалавр түүнээс дээш 		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> • Инженер, эдийн засаг, санхүү, нягтлан бодох 		
Мэргэшлийн бэлтгэл	<ul style="list-style-type: none"> • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авалтын чиглэлээр сургалтанд хамрагдсан байх, • Аудиторын сургалтанд хамрагдсан байх 		
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбарт 5-с доошгүй жил, дотоод хяналтын чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан байх, 		
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • асуудлыг судлан үзэж, оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх, • багаар ажиллах, 		
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> • хүчин төгөлдөр АЗ сертификаттай байх, • авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, • байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах, 		
VI. Ажлын байрны хангамж, эд хөрөнгө, нөөц хэрэгсэл			
Цалин	<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал 		
Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • албан өрөө, тавилга, эд хөрөнгө, компьютер, холбогдох техник хэрэгсэл 		
VII. Ажлын байрны онцлог			
<ul style="list-style-type: none"> • Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллана. 			
VIII. Ажил үүргийн хүрээнд эдлэх эрх			
<ul style="list-style-type: none"> • Өөрийн үйл ажиллагаатай холбоотой Үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэрийн төсөлтэй танилцах, • Энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар удирдлагад санал тавих, • Хяналт шалгалт явуулахдаа үйлдвэрийн газрын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, баримт, судалгаа авах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах; • Өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцад илрүүлсэн Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбогдолтой алдаа дутагдлыг өөрийн шууд удирдлагад мэдээлэх, арилгах санал оруулах, • Өөрөө болон шууд удирдлагын өгсөн үүрэг даалгаврын дагуу харъяа үйлдвэрүүдийн удирдлага болон мэргэжилтнүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулах, тэднээс шаардлагатай мэдээ мэдээлэл лавлах, авах, • Ажил үүргийн дагуу өөрийн эрх, үүргийг гүйцэтгэхдээ Үйлдвэрийн газрын удирдлагаас тусламж хүсэх. 			
IX. Ажлын үр дүнгээр хүлээх хариуцлага			
<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд энэхүү ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг биелүүлээгүй эсвэл зохих есоор биелүүлээгүй бол, 			

- Өөрийн ажил үүргийг гүйцэтгэх явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй захиргааны, иргэний болон эрүүгийн хуульд заасан зөрчил гаргасан бол,
- Үйлдвэрийн газарт эд материалын хохирол учруулсан бол учирсан хохирлын хэмжээгээр Монгол Улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн болон иргэний хууль тогтоомжийн хүрээнд,
- Хөдөлмөрийн сахилга бат, Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн бол,
- Боловсруулсан баримт бичгийн утга агуулгад алдаа гаргасан, түүний улмаас байгууллагад хохирол учруулсан бол,
- Үйлдвэрийн газрын нууц задруулсан бол.
- Удирдлагаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх буюу ажил үүргээ бусдаар гүйцэтгүүлэхийг хатуу хориглоно. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

**Ажлын байрны тодорхойлолтыг
баталсан:**

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын
Захирал


..... Д.ТОГТОХСҮРЭН



20 25 оны 03 сарын 26-ны өдөр

**“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН ДОТООД ХЯНАЛТЫН, МЭРГЭЖИЛТЭН НИЙ [1]
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

I. Ерөнхий мэдээлэл	
Байгууллагын нэр	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
Нэгжийн нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс
Ажлын байрны нэр	Дотоод хяналтын мэргэжилтэн (ЭБАТ)
Албан тушаалын ангилал	Албан хаагч
Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	Дотоод хяналт, мониторингийн хэлтсийн дарга
Ажлын байранд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр	-
